

<https://doi.org/10.69561/mjac.v25i48.3620>

Article | Fasc.5

Таксидерми буюу амьтны чихмэлийн тухай асуудалд

Түвдэндоржийн Дашбат

Соёл урлагийн их сургуулийн Соёлын сургууль, Улаанбаатар, Монгол Улс

ORCID: <https://orcid.org/0009-0009-2799-239X>

Холбоо барих зохиогч: dashbatt@gmail.com

Хураангуй: Монгол Улсад музей хэмээх соёлын байгууллага албан ёсоор байгуулагдсанаас хойш 100 жил болжээ. Дээрх хугацаанд үе үеийн судлаачид Монгол орны байгаль, түүх, соёлын илэрхийлэл болох эд зүйлийг цуглуулж, боловсруулж музейн үзүүллэгт дэглэсээр ирсэн. Байгалийн чиглэлийн үзмэрүүд дотроос амьтны чихмэл голлох үүрэг гүйцэтгэсээр байна. Бид уг судалгаагаар амьтны чихмэл (Taxidermy) гэж юу вэ? Түүний үүсэл, түүхэн хөгжил, үнэ цэн, хүн төрөлхтөн хэрхэн ашиглаж ирсэн туршлагыг судалж, дүрслэх урлагийн нэг төрөл мөн болохыг баталж, цаашид музейн хөгжил, соёлын орон зайд ямар байр суурь эзэлж, хаана ямар зориулалтаар ашиглаж байгаа талаар судаллаа. Судалгаандаа түүхэн материалын арга, анализ синтез, герменевтик, жишин харьцуулах, баримт бичигт шинжилгээ хийх зэрэг аргуудыг голлон хэрэглэсэн.

Түлхүүр үгс: амьтны чихмэл, таксидерми, таксидермийн түүх, соёл дахь таксидерми

Some issues on taxidermy

Dashbat Tuvdendorj

School of Culture, Mongolian National University of Arts and Culture, Ulaanbaatar, Mongolia

ORCID: <https://orcid.org/0009-0009-2799-239X>

Corresponding author: dashbatt@gmail.com

Abstract: It has been 100 years since the official establishment of a cultural institution called a museum in Mongolia. During the above period, researchers have been collecting and processing specimens and artifacts that represent the nature, history, and culture of Mongolia and prepared for exhibitions of museums. Stuffed animals continue to play a major role in the natural museums. In this research, we have studied what taxidermy is, its origin, historical development, and the experience of how humans have used it, and in the future, what place it occupies in the museum development and cultural space, and where it is used for what purpose.

Keywords: stuffed animals, taxidermy, history of taxidermy, taxidermy in culture



Оршил

Монгол Улсын анхны шинжлэх ухааны байгууллага болох Судар бичгийн хүрээлэнгийн судлаачид 1921 оны намраас Монгол орны байгаль, түүх, соёлын дурсгалт зүйлийг цуглуулах, бүртгэл тодорхойлолт бичих ажлыг гүйцэтгэж, улмаар 1924 оны 12 дугаар сарын сүүлчээр музей хэмээх соёлын байгууллага түмэн олондоо үүд хаалгаа нээсэн түүхтэй.

Орчин цагийн музейн хэв шинжийг агуулсан байгууллага үйл ажиллагаагаа эхлүүлсэн нь монголын ард түмэн чихмэл амьтадтай танилцах боломж бүрджээ. 1956 оноос Улсын төв музей байгуулагдаж, тус музей нь өөрийн сан хөмрөгийг баяжуулахаас гадна орон нутаг судлах танхимуудыг чихмэл амьтаар үзмэр баяжилт хийх үүрэг хүлээн ажиллаж байжээ. Улмаар музейг төрөлжүүлэн хөгжүүлэх төрийн бодлогын дагуу БНМАУ-ын Засгийн газрын дэргэдэх Соёл урлагийн хөгжлийн хорооны даргын 1991 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 214 дугаар тушаалаар Улсын төв музейн Байгалийн тасгийг өргөжүүлэн, Байгалийн түүхийн музей нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн байна. Байгалийн түүхийн музейн голлох үзмэрүүдэд амьтдын чихмэл тодорхой байр суурь эзэлсээр өнөөдрийг хүрчээ. Монголчууд бид амьтны бүтэн чихмэлтэй танилцаад 120 гаруй жил, өөрсдөө хийж, бүтээж, хөгжүүлж эхлээд 100 гаруй жил болжээ.

Бидний хувьд амьтны чихмэлийн талаар нийгэмд шинжлэх ухааны үндэслэлтэй ойлголт өгөх, үнэлэмжийг нэмэгдүүлэх, ач холбогдлыг нь тодорхойлох, хүн төрөлхтний чихмэл амьтдыг бүтээж, ашиглаж ирсэн туршлага дээр тулгуурлан цаашид музейн хөгжил, соёлын орон зайд ямар байр суурь эзэлж, ямар түвшинд хэрэглэгдэж болохыг тодорхойлох шаардлагатай гэж үзсэн.

Судалгааны арга зүй

Тус судалгааны ажилд түүхэн материалын арга, анализ синтез, герменевтик, жишин харьцуулах, баримт бичигт шинжилгээ хийх зэрэг аргуудыг хэрэглэснээс гадна зан үйлийн онол, соёл судлал, гоо зүйн онолыг хэрэглэв. Монгол Улсын Байгалийн түүхийн музейн чихмэлийн лабораторид 12 жил ажиллах хугацаандаа олж авсан мэдлэг, тэнд ажиллаж байсан үе үеийн чихмэлчидтэй хийсэн ярилцлага, эх хэрэглэгдэхүүнийг сурвалжлан тогтоох, ном сурах бичиг, цахим холбоосыг шүүх зэргээр ажиллалаа. Байгалийн түүхийн музейн бүртгэл мэдээллийн сан дахь гар бичмэл болон цахим үнэ цэнтэй сурвалжид түшиглэн харьцуулан судалсан.

Судалгааны үр дүн

Таксидерми буюу амьтны чихмэл: Амьтны чихмэл болон түүнийг хийх үйл явцыг бүхэлд нь олон улсад **Taxidermy (Таксидермия)** гэж нэрлэдэг. Таксидерми гэдэг үг нь эртний грекийн taxis (эмх цэгц, дэг журам, зохион байгуулалт) derma (арьс) гэсэн 2 үгнээс гаралтай (Encyclopaedia Britannica, 2024.03.21).

Таксидерми гэдэг үгийг 1803 онд “Байгалийн түүхийн шинэ толь бичиг” (Nouveau dictionnaire d’histoire naturelle) лавлах номонд Парис дахь Байгалийн түүхийн үндэсний музейн ажилтан шувуу судлаач, таксидермист Луис Дюфрешн (Louis Dufresne) анх хэрэглэснээр энэ нэр томъёо гарч ирсэн. Харин амьтны чихмэл хийдэг хүнийг Таксидермист гэх болсон байна.

Таксидерми буюу амьтны чихмэл гэж юу вэ? Соёл урлагийн тайлбар толь III-т “Ихэвчлэн сээр нуруутан амьтны арьсыг зарим тохиолдолд эвэр, толгойн ясны хамт шинжлэх ухаан, сургалт, танин мэдэхүйн зорилгоор музейд дэглэх үүднээс арьсыг боловсруулан, тухайн амьтны биеийн галбир, хэмжээг алдагдуулахгүйгээр, зан төрхийн тодорхой нэг шинжийг илэрхийлэн гүйцэтгэсэн бүтээл” (Соёл урлагийн их сургууль 2017, 381) гэж тэмдэглэсэн байна.

Амьтны чихмэл буюу таксидермийн талаар бусад эх сурвалжууд хэрхэн тодорхойлсон талаар танилцуулъя. Таксидерми нь амьтдын, ихэвчлэн шувууд, хөхтөн амьтдын бэлтгэсэн арьс, төрөл бүрийн тулгуур бүтцийг ашиглан амьтны бодит дүр төрхийг бий болгох арга юм. Таксидерми нь анчид өөрийн агнасан анг хадгалж авч үлдэхийг хүсдэг байсантай холбоотой хөгжсөн байж болох ч түүнийг урлаг болгон хөгжүүлэх гол шалтгаан нь хүмүүс байгалийн түүхийг илүү сонирхож эхэлсэнтэй холбоотой. Таксидерми бий болсон нь музей үүсэн бий болсон үетэй давхацдаг гэх ойлголт түгээмэл боловч музейн анхны байгалийн чиглэлийн үзмэрүүд таксилермийг төлөөлөхөд бэрх юм. Өнөө цагт таксидермийг байгалийн түүхийн музейтэй холбон ойлгодог (Encyclopaedia Britannica, 2024.03.21).

Таксидерми гэдэг нь амьтны бодит дүрсийг бүтээх, хийх арга, технологи бөгөөд түүний үндэс нь амьтны арьс юм. Таксидермийг бүтээхдээ тодорхой суурин дээр карказ төмөр угсарч, хөндий зайг нь удаан хадгалж болохоор материалаар дүүргэн, амьтны анатоми, бүтцийг гаргаж, боловсруулсан бодит арьсыг ашиглан бодит хэмжээсээр нь хийдэг. Орчин үеийн таксидерми нь ихэвчлэн “манекен” (биеийн бүх хэсгүүдийн харьцаа, булчингийн эзлэхүүний анатомийн хадгалалт бүхий полиуретан хөөсөөр хийсэн биеийн бүтэц) ашигладаг.

Таксидерми нь голчлон сээр нуруутан амьтдад (хөхтөн, шувууд, загас, хэвлээр явагчид, хоёр нутагтан амьтад) хийгддэг боловч зарим тохиолдолд илүү том шавж, аалз, хилэнцэт хорхой зэрэгт хийж болно (Encyclopaedia Britannica, 2024.03.21).

Таксидермийн түүх: Амьтны арьсыг боловсруулж, ахуйдаа хэрэглэж байсан нь хүн төрөлхтний түүхийн туршид байсаар ирсэн. Дэлхийн хамгийн эртний таксидермийн хэлбэрийг эртний египетчүүд хөгжүүлсэн байдаг. Тэд хааны ордонд тэжээгдэж байсан амьтдыг арьсыг өвчиж авахгүйгээр бүхлээр нь занданшуулан оршуулж байжээ. Энэхүү занданшуулах арга нь үзэсгэлэн гаргах зорилгоор бус, харин тухайн үеийн уламжлал оюун санааны итгэл үнэмшилтэй холбоотой байсан. Хэдийгээр амьтдыг занданшуулах нь амьтны амьд дүр төрхийг тодорхой түвшинд агуулдаг боловч яг амьтны чихмэл (таксидерми) гэж тооцогддоггүй.

Эртний Грек, Ром, эртний Британи болон бусад хойд нутгийн хүмүүс амьтны арьсыг хувцас хэрэглэлд ашиглах зорилгоор идээлж, боловсруулж эхэлсэн бөгөөд тэдний нэгэн адил төв ази, хойд америкийн олон овог аймгууд арьсыг боловсруулж, хадгалж, хувцас хунар хийхийн зэрэгцээ төрөл бүрийн чимэглэлд ашигладаг байв. Өнөөдрийг хүртэл хойд болон өмнөд америкийн уугуул овгууд уламжлалаа хадгалж таксидермийг бий болгоход түлхэц өгсөн анхны хэлбэр болсон эд зүйлсийг ахуйдаа ашигласаар байна. Дундад зууны үед европт таксидермийн анхны хэлбэрүүд үүссэн.

Жон В.Мойер “Америкийн нэвтэрхий толь бичиг”-г дурдахдаа таксидермийн тухай хамгийн анхны хэвлэгдсэн бүтээлүүдийн нэг бол 1749 онд Францад

хэвлэгдсэн Рене Антуан Фершаул де Рэумурын “Түүхэн зохиол” юм гэж дурдсан. Энэ бүтээлд хоёр зуун гаруй жилийн өмнө чихмэл хийж байсан зарим техник, хадгалах аргын талаар бичигдсэн ч тэр үеийн таксидермистүүдийн дунд шинэлэг арга байж чадаагүй. Тэд шинэ арга барилыг эрэлхийлсээр улмаар Франц, Герман, Дани, Англид таксидермийн орчин цагийн хэлбэр үүсэж хөгжсөн. Тэд төрөл бүрийн шавар материалыг зөөлөн хэсгүүдийг хэлбэржүүлэхэд ашиглаж эхэлсэн нь дэвшилттэй боловч энэ нь чихмэлийг хүнд болгож байсан. Тэдний арга нь хэдэн арван жилийн туршид европын таксидермистүүдийн стандарт арга болж чадсан.

XVIII зуун гэхэд европт аж үйлдвэр хөгжиж ихэнх хотууд арьс ширний үйлдвэртэй болсон ч тэдний арьс боловсруулалтын технологи чихмэл хийхэд таарахгүй хадгалалтын хувьд хангалтгүй хэвээр байжээ. Францын Байгалийн түүхийн музейн шувуу судлаач, таксидермист Луис Дюфресн “Байгалийн түүхийн толь бичиг” (Nouveau dictionnaire d’histoire naturelle) (1803) сэтгүүлд хүнцлийн саван ашиглан чихмэлд зориулж арьс идээлэх аргыг нийтэлсэн байна (Encyclopaedia Britannica, 2024.03.21). Дюфресний арга XIX зууны эхэн үед Англид тархсан бөгөөд тэнд түүний аргаар боловсруулж хийсэн бүтээлийг хэрхэн хадгалах, хоргүй аргуудыг Роуланд Уорд, Монтег Браун зэрэг тухайн үеийн амьтан судлаачид боловсруулсан. 1800-аад оны сүүлээр британийн таксидермистууд Лондонд Роуланд Уордын студи байгуулжээ.

XVII зууны дунд үед дэлхийн хамгийн их амьтны цуглуулгатай байсан музей бол Британий музей юм. Тус музейд 1759 оны байдлаар 1886 хөхтөн амьтан, 1172 шувуу, 521 хэвлээр явагчид, 1555 загас байсан гэсэн мэдээлэл бий. Тэдгээр нь бүгд чихмэл биш, яс, зүгээр дэлгэж боловсруулсан арьс зэрэг байв. Дээрх үзмэрүүд олон нийтийн сонирхлыг ихэд татаж, музейн нэр хүндийг 1800-аад он хүртэл дэлхийд тэргүүлэхэд хүргэсэн. Музейн судлаачид болон таксидермистүүд амьтадын чихмэлийг олон нийт ихэд сонирхож, цаашид ийм төрлийн үзмэрт таатай хандах хүсэл эрмэлзэл байгааг олж мэдсэн. 1851 онд Лондонд дэлхийн өнцөг булан бүрээс олон тооны үзмэрүүдийг янз бүрийн хэлбэрээр дэлгэн үзүүлсэн түр үзэсгэлэнг зохион байгуулсан байна. Энэ нь түүхэнд анх удаа дэлхийн өнцөг булан бүрээс таксидермистууд цугларч, урлагт хамаарах орчин үеийн, шинэлэг аргуудыг танилцуулсан явдал байв. Энэ нь цаашид таксидермийг загварчлахад түлхэц өгсөн хамгийн онцлох үйл явдал болсон.

1867 онд Парист мөн энэ чиглэлийн үзэсгэлэн гарч, европын таксидермистүүдийн амьтдын анатомийн хөдөлгөөн, онцлогт илүү их анхаарал хандуулах болж үзэсгэлэн нь таксидерми орчин үеийн хэлбэрт шилжсэнийг харуулсан.

Хэдийгээр таксидермийн эхэн үеийн үндэс нь Африк, баруун европт хөгжсөн боловч орчин үеийн таксидерми нь 1861 онд Нью-Йорк хотод Генри Август Уорд Байгалийн шинжлэх ухааны байгууллагыг үүсгэн байгуулснаар АНУ-д орчин цагийн таксидермийн урлагийн хөгжил тавигдсан гэж үздэг. Энэ байгууллагаас олон таксидермистүүд өөрсдийн карьераа эхлүүлсэн байдаг.

1880 оны 3 дугаар сарын 24-нд Америкийн таксидермистүүдийн нийгэмлэгийг Уордад үүсгэн байгуулжээ. Энэ нийгэмлэг нь АНУ-д анх удаагаа эрдэм шинжилгээний илтгэлүүдийг хэвлүүлж, 3 удаа өрсөлдөөнт үзэсгэлэн гаргасны эхнийх нь 1880 онд Рочестерт, хоёр дахь нь 1881 онд Бостонд, гурав дахь нь 1883

оны 4 дүгээр сарын 30-аас 5 дугаар сарын 5-нд Нью-Йорк хотод тус тус байдаг. Тухайн үеийн Америкийн хамгийн чадварлаг таксидермистүүдээс бүрдсэн нийгэмлэг нь олон нийтэд орчин үеийн арга, техникийг танилцуулж, чөлөөтэй ярилцаж, арилжааны ажил, музейн үзмэрүүдийг илүү өндөр стандартад хүргэхэд үйлчилсэн. Чухам энэ үед амьтдын “чихмэл” нь уран нарийн хийцтэй урлагийн төрөл болж хувирсан юм. XX зууны эхэн үед Америкт амьтан судлаач Карл Э. Акели, Хорнадей, Леон Прэй зэрэг хүмүүс техникийг боловсронгуй болгож, уран сайхны ур чадварыг онцолж эхэлсэн байна.

Таксидерми нь Америкт гар урлалын нэгэн төрөл болж байсны нэг илрэл нь америкийн скаутуудын эзэмших ёстой ур чадваруудын нэг гэж үзэн, эзэмшсэн тохиолдолд тэмдгээр шагнуулдаг байж. Тэрхүү тэмдгийг 1911 онд анх нэвтрүүлж, 1954 он хүртэл олгож байсан бөгөөд энэ хугацаанд 10,344 скаут энэхүү тэмдгийг хүртэж байжээ. 1954 оноос энэхүү скаутын эзэмших шалгуур үзүүлэлтээс энэхүү чадварыг хассан байна.

1970 онд Америкт таксидермийн сургуулиуд нээгдэж, ирээдүйн уран бүтээлчдэд амжилтанд хүрэх итгэл найдвар төрүүлэв. 1971 онд Үндэсний таксидермийн нийгэмлэг байгуулагдсан. 1974 онд “Таксидермийн тойм” (Taxidermy Review) нэртэй худалдааны сэтгүүл хэвлэгдэн гарч үндэсний чихмэлийн аварга шалгаруулах тэмцээнүүдийг ивээн тэтгэж эхэлсэн. Түүхэнд анх удаа Америкийн таксидермистүүд чихмэлийг хэл буйлыг гарган хийж эхэлж, амьтнаас хэмжээ авч бодит хэлбэрийг бүтээх аргыг сайжруулсан байна. Ийм аргуудын дийлэнх нь өнөөдөр таксидерми дэлгүүрүүдэд ашиглагдаж байгаа бөгөөд энэ нь дадлагажигчдад бэлэн бүтээгдэхүүн дээр ажиллах боломж олгодог.

Орост I Петр хааны үед чихмэл хийх урлаг хөгжсөн. Петербургийг нийслэл болгож, 1698 онд Голландаас олон тооны чихмэл шувуу авчирсан байдаг. Энэ нь Петербург хот дахь Кунсткамер музейн үндэс суурь болсон гэж үздэг. Шинжлэх ухааны ерөнхий хөгжлийг дагаад таксидерми хийхэд ашигладаг арга, материалууд сайжирч, зөвхөн XIX зууны эхээр төгс гүйцэтгэлтэй чихмэлүүд гарч ирэв. 1804 онд таксидермийн анхны гарын авлага орос хэл дээр хэвлэгджээ (Шкулёв 2014, 32).

XIX зууны эхээр Москвад Ф.К.Лоренц гэх хүн таксидермийн анхны сургуулийг байгуулсан байна. XX зууны 20-оод онд америкийн таксидермист Карл Э. Акелийн чихмэл хийх арга барилыг М.А. Заславский чихмэл хийх арга барималдаа ашиглаж эхэлснээр чихмэл хийх урлаг Орост үсрэнгүй хөгжих боломж бүрдсэн гэж үздэг. Өнөөдөр ОХУ-ын Санкт-Петербург хотод байрлах, 1988 онд байгуулагдсан Владимир Сухоревагийн таксидермийн студи полиуретан хөөс ашиглан сайн чанарын чихмэлүүдийг бий болгосоор байна.

Монголд 1841 онд судалгаа хийж байсан Оросын хаант улсын судлаач Габер Дагуур огдойн *Ochotona dauurica* (Pallas, 1776) чихмэлийг хийсэн нь Байгалийн түүхийн музейн сан хөмрөгт Y-1841-01 хувийн дугаартай хадгалагдаж байна. Энэхүү чихмэл монголын газар нутаг дээр хийгдсэн анхны чихмэл хөхтөн амьтан байх магадлалтай. Монгол Улсын сүүлчийн хаан VIII Богд Жавзандамба хутагт 1901 онд Герман улсаас олон төрлийн чихмэл амьтан авчирсан нь монголчууд чихмэл хэмээх урлагтай танилцахад түлхэц өгсөн. Улмаар 1924 онд албан ёсоор музей гэх байгууллагыг байгуулж, монголчууд чихмэл хийж эхэлсэн байдаг.

Түүнийг гэрчлэх чихмэл үзмэр 1932 онд “Чөтгөр” хэмээх Н.Дэндэвийн бүтээсэн Y-32-01 хувийн дугаартай Байгалийн түүхийн музейн сан хөмрөгт хадгалагдаж байгаа “Хүрэн баавгай” (*Ursus arctos Linnaeus, 1758*)-н чихмэл юм.

1957 онд Лхамжавын Цэвэлийг ЗХУ-ын Москва хотод Зоологийн их сургуульд чихмэлчнээр сургасан (Тодгэрэл 2017, 5) нь Монголд орчин цагийн чихмэлийн урлаг хөгжих боломж бүрдсэн. Өнөөдрийг хүртэл түүний хөгжүүлсэн чихмэлийн лаборатори үйл ажиллагаагаа хэвийн явуулж орчин цагийн чихмэл хийх дэвшилтэд технологийг нэвтрүүлсээр байна. Л.Цэвэл Улсын төв музейд 38 жил ажилласан бөгөөд түүний үйл хэргийг түүний шавь болох Д.Дагиймаа, Ж.Цогтбаяр нар үргэлжлүүлж, олон арван бүтээл туурвисан нь Байгалийн түүхийн музейн үзүүлэлт дэглэгдэн үзэгчдийн хүртээл болсоор байна. Өнөө цагт монголын залуу уран бүтээлчид чихмэл амьтдын хөдөлгөөн, өгүүлэмж зэрэгт илүү анхаарч бүтээл талаас нь хөгжүүлсээр байна. Тэдний тод илрэл, төлөөлөл болох уран бүтээлч бол Д.Отгонсайхан юм. Түүний бүтээлүүд монголын чихмэл хийх урлагт шинэ өнгө төрх авчирч, дэлхийн өндөр хөгжилтэй орнуудын чихмэлчдийн арга барилыг нэвтрүүлж чадсан.

Таксидерми ба нийгэм, соёлын харилцаа

Таксидерми буюу чихмэл хийх үйл явц музейн үүсэл хөгжилтэй хамт хөгжиж ирсэн нь түүний түүхэн хөгжлийн судалгаанаас харагдаж байна. XIX зуунд таксидермийг интерьер дизайн, чимэглэлд ашиглаж эхэлсэн нь түүний хөгжлийг улам хурдасгасан. Тухайн үед хүн үхсэн амьтдыг буцаан амьд юм шиг “сэргээж” чадна гэсэн ойлголтыг баталгаажуулж, харуулж чаджээ. Мөн үхсэн тэжээвэр амьтдыг эзэд нь чихмэл болгон хадгалах үзэгдэл нэмэгджээ (*Encyclopaedia Britannica, 2024.03.21*). XVIII зууны дунд үеэс хөгжлийнхөө чиг хандлагыг тодорхой болгосон таксидерми буюу амьтны чихмэл хийх арга технологи, бүтээлүүд нь өнөө цагт дараах зориулалтаар ашиглагдаж байна. Үүнд:

- 1. Музейн үзүүлэлт дэглэлтэд.** Байгалийн чиглэлийн музейнүүдийг чихмэл амьтадгүйгээр төсөөлөх боломжгүй юм. Амьтны чихмэлүүд нь музейн хөгжлийн үе шатуудад голлох үзмэрт зүй ёсоор тооцогдож ирсэн бөгөөд цаашдаа ч ач холбогдол нь буурахгүй нь харагдаж байна. Байгаль ан амьтантай хамгийн ойроос танилцах хэлбэр бол музей гэж үзсэн үзэл үргэлжилсээр.
- 2. Ан агнуурын түүх, цомыг хадгалахад.** Хүн төрөлхтөн үүсэн бий болсон цагаасаа эхлэн ан гөрөө хийж анхдагч хэрэгцээгээ хангаж ирсэн. Сүүлийн үед дэлхийн улс орнууд байгалийн тэнцвэрт байдлыг хадгалсан зохистой ан гөрөөг, аялал жуулчлалтай холбон хөгжүүлж, анчид шилдэг ангийн олзворыг хадгалж үлдэх зорилгоор чихмэл хийлгэсээр байна. Мөн энэ төрлийн сонирхогчдын дунд чихмэл бүтээлийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээн уламжлал болон зохион байгуулагдаж ирсэн.
- 3. Тэжээвэр амьтдыг дурсахад.** Энэ тохиолдлоор чихмэл хийлгэх нь төдийлөн олон биш ч гэсэн нийгэмд үзэгдсэн хэвээр байна. Зарим тохиолдолд аюулгүй байдлын албан үүрэг гүйцэтгэж байсан амьтдыг хийх тохиолдол байдаг.
- 4. Бүх шатны боловсролын хэрэглэгдэхүүнд.** Хүүхдүүдэд хүрээлэн буй

орчинд амьдарч байгаа суурин болон зэрлэг амьтдын талаар мэдлэг олгох, хичээлийн хэрэглэгдэхүүн болгох зорилгоор чихмэл бүтээлүүдийг биологийн хичээлийн анги танхимуудад байршуулах нь элбэг.

5. **Ховордсон буюу устаж үгүй болсон амьтдын түүхийг хадгалахад.** Музей болон шинжлэх ухааны байгууллагууд ховордсон устах аюултай ангилалд байгаа амьтдын дээжийг хадгалж авч үлдэх, хорогдлын шалтгааныг судлан түүгээр дамжуулж байгаль эх дэлхийд тулгараад байгаа бодит асуудлыг нийгэмд таниулах зорилгоор хийж бүтээдэг.
6. **Бөөгийн тахилга ёслолд.** Үүнд бүх төрлийн амьтдын чихмэл хамаардаггүй. Тодорхой хэдэн зүйл амьтныг ашигласаар ирсэн.
7. **Интерьер дизайн.** Барилга баригдсан газрын орчин, дотоод засалд нийцүүлэн чихмэлийн төрөл бүрийн хэлбэрийг байршуулан өрөө тасалгааг чимэглэх тохиолдол байдаг. Энэ нь европ, хойд Америкт илүү хөгжсөн.

Чихмэлчин хүн (таксидермист) бол юуны түрүүнд амьтны анатомийн талаар асар их мэдлэгтэй зураач, барималчин, сийлбэрчин байх шаардлагатай гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Чихмэл хийхэд олон төрлийн ур чадвар, техник ажиллагаа шаарддаг. Үүнд, чихмэл амьтан хийхэд хамгийн эхний ажил бол арьсыг боловсруулах явдал юм. Үүний дараа амьтны бүх эрхтэн, булчингийн эдийг харгалзан амьтны бодит дүрийг бүтээдэг. Хоосон зайг ихэвчлэн тусгай полиуретан хөөсөөр дүүргэдэг. Шилэн линзийг нүд болгон ашигладаг. Лав, шаврыг ихэвчлэн уруул, ам зэрэг хэсгүүдийг сэргээхэд ашигладаг. Дээрх чихмэл хийх үйл явцыг харвал чихмэл нь гар урлалын бүтээл болж байгаа нь харагдаж байгаа нь чихмэл хийх үйл явцыг дүрслэх урлагийн нэгэн төрөл гэж авч үзэх үндэслэлтэйг харуулж байна. Амьтны чихмэл хийж ирсэн хөгжлийг харвал анхны чихмэлийг анатомийн шинж чанарыг харгалзахгүйгээр хийсэн. Амьтны арьсыг зүгээр л янз бүрийн өөдсөөр дүүргэсэн бөгөөд үүний үр дүнд чихмэл нь тухайн амьтны бодит төрхийг илэрхийлэх боломжгүй. Өнөөдөр ингэж хийгдсэн чихмэлүүд устаж үгүй болсон амьтны зүйлийг судлахад эрдэмтдэд маш их төөрөгдөл үүсгэдэг. Одоог хүртэл нийгэмд чихмэл, түүний хийх арга барил, технологийг дээрх байдлаар хийдэг гэсэн ойлголт түгээмэл байна.

Хэлэлцүүлэг

Орчин цагийн чихмэл бүтээлүүд нь уран сайхны илэрхийлэл өндөртэйн дээр хүч чадлын хувьд уран зураг, уран баримлын бүтээлүүдтэй эн зэрэгцэж чаддаг. Бүтээл бүхэн дахин давтагдашгүй өвөрмөц цорын ганц байдгаас гадна тухайн чихмэлчний өөрийн гэсэн хэн ч хэрэглэдэггүй арга барил нууцыг шингээсэн байдаг. Энэ бол тэдний үнэ цэнийг тодорхойлж, урлагийн бүтээл гэж харах үндэслэлтэй юм. Гэвч чихмэлийг өөр өнцгөөс харж байгаа таагүй шүүмжлэлийг анхаарахгүй орхигдуулж болохгүй. Тэд чихмэлийг зөвхөн амьтан устгаж байгаа хэлбэр гэж ойлгодог. Тэдний хэвшмэл ойлголтыг эвдэх нь амаргүй, заримдаа бүр боломжгүй юм. Иймд цаашид чихмэлийг хэрхэн авч үзэх, хэрэв ашиглавал ямар зориулалтаар ашиглах, хэрхэн бүтээх талаар нарийвчлан судлах шаардлагатай.

Монгол Улсын Засгийн газар Байгалийн түүхийн музейн үйл ажиллагааны чиглэлийг өргөжүүлж, бүс нутагтаа өрсөлдөхүйц түвшний байгалийн шинжлэх

ухааны үндэсний хэмжээний музей байгуулах зорилгоор шинэ барилгын ажлыг эхлүүлээд байна. Тун удахгүй шинэ барилгад үндэсний хэмжээний үйл ажиллагаа явуулах төлөвлөгөөтэй ажиллаж буй байгалийн шинжлэх ухааны төрөлжсөн музейн үзэл баримтлалын төслийг үзвэл үйл ажиллагааны үндсэн чиглэл дотор “амьтны чихмэл хийх” гэж оруулж, цуглуулгын бодлогод “Сээр нуруутны сан хөмрөгийг загас, хоёрнутагтан, мөлхөгч, шувуу, хөхтөн амьтны зүйлүүдийн чихмэл, арьс, нойтон бэлдмэл, хэлхээ яс, толгойн яс, өд, эвэр, сарвуу гэх мэт цуглуулгын төрлөөр нь тус тус баяжуулна” тусгажээ. Мөн музейн нийгэм эдийн засгийн ач холбогдол дотор “Байгаль, палеонтологийн үзмэр, цуглуулгыг боловсруулах, сэргээн засварлах, судалгаа шинжилгээ хийх мэргэжлийн лабораториудтай болсноор үндэсний хэмжээнд музейн үзмэрийг бэлтгэн нийлүүлнэ” гэсэн байна. Дээрх үзэл баримтлалыг үзвэл, Байгалийн түүхийн музей нь амьтны чихмэлийг цаашид үргэлжлүүлэн бүтээж, үзүүлэг дэглэлтэндээ ашиглахаас гадна улсын хэмжээнд амьтны чихмэл шаардлагатай байгаа музейнүүдэд нийлүүлэхээр төлөвлөж байгаа нь харагдаж байна.

Өөр нэг эх сурвалжийг харвал түүнд: Музей дэх чихмэл амьтад байгаль дээрх амьтдыг ойроос харах, илүү бодитоор мэдрэх боломжийг олгодог. Бидний эргэн тойронд байгаа бүх технологиос үл хамааран олон хүн таны өмнө “жинхэнэ мэт” амьтан байх нь үргэлж илүү мэдрэмж төрүүлнэ гэдэгт итгэдэг гэсэн байна (Encyclopaedia Britannica, 2024.03.21). Цаашид чихмэлчид болон чихмэл сонирхогчдын ажлын ур чадвар, ёс суртахууны хэм хэмжээ, музейн цуглуулгын бодлого зэрэг нь амьтны чихмэлийн үнэ цэнийг тодорхойлж, нийгэмд эерэг нөлөөг авчирна гэдэгт эргэлзэхгүй байна.

Дүгнэлт

Амьтны чихмэл хийж эхэлсэн түүхийг музей үүссэн цагтай холбон ойлгодог судлаачид цөөнгүй бий. Музей үүссэн цагийг судлаачид НТӨ VI зууны үеэс эхлэлтэй хэмээн үздэг (Мөнхтогоо, Мөнхжаргал 2022, 4) бөгөөд тэр цаг үеийн байгалийн чиглэлийн цуглуулгад бидний ойлгож буй (Taxi-der-my) таксидермийг бүрэн илэрхийлэх үзмэр байсан гэх нотолгоо одоогоор алга байна. Ихэвчлэн сээр нуруутан амьтны арьсыг ашиглан түүний бодит төрхийг бий болгож байгаа үйл явц, бүтээлийг таксидерми гэдэг (Gilman 1991, 1209). Таксидермийн анхны хэлбэрүүд дундад зууны үед европт үүссэн нь баримтаар нотлогддог.

Чихмэл амьтдыг хийж ирсэн түүхэн хөгжил, бүтээж буй арга технологи, чихмэлчдийн ур чадвар зэргээс харвал, амьтны чихмэл нь гар урлалын хосолсон хэлбэрийг илэрхийлж байгаа бөгөөд түүнийг дүрслэх урлагийн нэгэн төрөл гэж үзэн шилдэг бүтээлүүдийг нь урлагийн бүтээл болгон үзэх бүрэн үндэслэлтэйг бидний хийсэн судалгаа харуулж байна.

Чихмэлчдийн зорилго бол амьтныг байгаль дээр байхдаа ямар харагддаг яг тэр түвшинд босгож, амьд мэт мэдрэмжийг төрүүлэх, бүтээлийг удаан хадгалах аргыг тогтмол судалж хөгжүүлэх, чихмэлийг шинжлэх ухааны эргэлтэд оруулах, чихмэлээр дамжуулж ан амьтдын талаар мэдлэг олгох, байгаль, эх дэлхийгээ хайрлах үзлийг төлөвшүүлж, чихмэлийн талаар нийгэмд зөв ойлголтыг өгөхөд оршино.

Өнөө цагт дэлхийн уур амьсгал хурдацтай өөрчлөгдөж, байгаль экологийн тэнцвэрт байдал алдагдаж, биологийн төрөл зүйлүүд устаж байгаа энэ үед амьтны чихмэлийг ямар түвшинд авч үзэх, музей нь цуглуулгын бодлогоо хэрхэн тодорхойлох, иргэдэд ямар байр сууринаас танилцуулах, цаашид нийгэм, соёлын орон зайд эзлэх байр суурь, нөлөөллийн асуудлыг нарийвчлан судлах шаардлагатайг харуулж байна.

Үе үеийн чихмэлчдийн ур ухаанаа шингээн бүтээсэн амьтны чихмэлүүд биологийн олон янз байдлын түүхэн гэрч болон үлдэхээс гадна хүн төрөлхтний түүхийн салшгүй нэг хэсэг болон хөгжиж, соёлын орон зайд олон чиглэлээр хэрэглэгдэн үнэт зүйл болсоор байна.

Ашигласан материалын жагсаалт

Монгол хэлээр:

Байгалийн түүхийн музей. 2008. *Байгалийн түүхийн музейн үзмэр, эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэл № 9-12*, Улаанбаатар.

Дэлхийн банк, Лондоны амьтан судлалын нийгэмлэг. 2007. *Монгол Улсын хөхтөн амьтны улаан данс*. Ред: Дуламцэрэн С., J. E. M. Baillie., M. Stubbe. Улаанбаатар: Адмон

Мөнхтоого. Д., Мөнхжаргал. Ч, 2022. *Музей судлал гарын авлага*. Улаанбаатар: Линограф.

Монголын үндэсний музей. 2012. *Монголын музей. Архивын баримтын эмхэтгэл*. Ред. Саруулбуян Ж., Мэндсайхан Х. Улаанбаатар: Соёмбо принтинг.

Соёл, спорт, аялал жуулчлалын яам, Монголын үндэсний музей. 2014. *Монголын музейн түүхэн замнал*. Ред. Цэндсүрэн Ц., Улаанбаатар.

Соёл урлагийн их сургууль. Соёл, урлаг судлалын хүрээлэн. 2017. *Соёл урлагийн тайлбар толь, Боть III: Музей*. Улаанбаатар: Мөнхийн үсэг.

Төрийн хэлний зөвлөл, Шинжлэх ухааны академи, Хэл зохиолын хүрээлэн, Хэрэглээний хэл шинжлэлийн сектор, Биологийн хүрээлэн, Шувуу судлалын лаборатори. 2007. *Монгол орны шувууны зүйлийн нэрийн арван хэлний толь*. Улаанбаатар.

Тодгэрэл, Т., Соронзонболд, О. 2014. “Байгалийн түүхийн музейн шувууны сан хөмрөг.” *Байгалийн өв судлал 01*: 89-115.

Тодгэрэл, Т. 2014. “Байгалийн түүхийн музейн хөхтөн амьтны сан хөмрөг.” *Байгалийн өв судлал 01*: 122-149.

Гадаад хэлээр:

Заславский, М.А. 1966. *Изготовление чучел птиц, скелетов и музейных препаратов* Москва: Академия наук СССР Зоологический институт: Наука.

Шкулёв, А. 2014. “Таксидермия-ремесло и искусство.” *Мордовский заповедник* 07: 32-33.

Frederick C Mish., E Ward Gilmanв 1991. s.v. “Taxi-der-my (1820).” *Westers Ninth New Collegiate Dictionary*.

Moyer, John W. 2009. s.v. “Taxidermy” *Encyclopedia Americana*. Scholastic Library Publishing

Цахим эх сурвалж:

Encyclopaedia Britannica. s.v. “Taxidermy.” 2024.03.21. <https://www.britannica.com/science/taxidermy>.

Таксидермия. 2024.03.22. <https://dzen.ru/>

<https://australian.museum/learn/teachers/classroom-activities/taxidermy/> 2024.03.22

Хавсралт



Зураг 1. Бүтээлч Т.Даибат. 2024.
Үлэг харцаганы чихмэл
Accipiter gentilis (Linnaeus, 1758).
Northern Goshawk (Англи)



Зураг 2. Бүтээлч Т.Даибат. 2013.
Саарал чонын чихмэл
Canis lupus Linnaeus, 1758.
grey wolf (Англи)